НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 05 өдөр Дугаар А/103 . Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан дөрвөн аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэн С.Нарантуяагийн "Тавлаг" дэн буудлын 13/101, Касио ХХК "Ану" дэн буудлын 13/124, Болорцэн ХХК "Эрч" зочид буудлын 13/247, Иргэн Б.Баярмагнай "Ска" зочид буудлын 13/93, Одод ХХК "Вояж" зочид буудлын 13/225 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.Batsuh Д.БАТСҮХ

УОА0453

E:\NAJG\Alban blanknii helvlelt\Tushaal\A\16.12.06 A103.docx

1150500287

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2016 оны 12 сарын 05-ны өдрийн А/103 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2016.12.05 Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Болорцэн ХХК	2584905	Эрч	Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 137 б
2	Одод ХХК	2066505	Вояж	Баянгол дүүрэг, 3-р хороо, Нарны зам-60
3	Иргэн Б.Баярмагнай	УЖ69021617	Ска	Баянгол дүүрэг, 18-р хороо, Л.Энэбишийн гудамж 89

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2016 оны 12 сарын 05-ны өдрийн А/103 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

УОА0453

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2016.12.05 Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Б.Баярмаа	ДМ77052901	Болор-2	Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Намъянжугийн гудамж 32
2	Иргэн С.Нарантуяа	ХБ66030462	Тавлаг	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, Өлгийн 28/363
3	Касио ХХК	2664402	Ану	Сонгинохайрхан дүүрэг, 27-р хороо, Толгойтын гудамж 22
4	Иргэн Д.Ганбаатар	ЧБ73033115	Лонг Лайф	Баянгол дүүрэг, 8-р хороо, 7-р байр 1,2 тоот

-ооООо-